

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2025/023-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
2025 он	Аудитын менежер: Х.Женисбек
	Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	“Анализ старт аудит” ХХК-ийн захирал: Н.Энхтуяа
	Утас: 99075818 Цахим хаяг: asaudit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 5 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ А.ЕРКЕГҮЛ ТАНАА

2025.02.21 № 83
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь 2024 онд 5,648.1 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 5,332.4 сая төгрөг зарцуулж, 94.4 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	479,307,655.60	480,196,042.04
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	350,665,873.00	333,719,181.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	350,665,873.00	333,719,181.00
3121	Төгрөг	350,665,873.00	333,719,181.00
31211	Төрийн сангийн харилцах	350,665,873.00	333,719,181.00
33	АВЛАГА	11,622,675.00	82,421,445.32
335	Бусад авлага	11,622,675.00	82,421,445.32
3351	Байгууллагаас авах авлага	11,622,675.00	68,170,745.32
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	14,250,700.00
35	БАРАА МАТЕРИАЛ	117,019,107.60	64,055,415.72
354	Хангамжийн материал	117,019,107.60	64,055,415.72
35410	Бичиг хэргийн материал	22,693,643.00	4,039,910.00
35420	Аж ахуйн материал	26,661,925.00	2,967,060.00
35440	Түлш, шатах тослох материал	796,750.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	66,866,789.60	57,048,445.72
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,580,744,809.22	4,883,358,321.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,580,744,809.22	4,883,358,321.50
392	Биет хөрөнгө	4,461,733,570.22	4,764,631,730.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,486,932,224.14	4,680,276,106.14
39202	Хуримтлагдсан элэгдэл	-375,607,264.60	-477,460,604.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	502,172,484.00	716,771,574.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-257,437,070.16	-326,106,992.23
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	215,152,428.60	260,064,420.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-149,483,068.76	-174,164,358.01
39217	Ном	40,003,837.00	85,251,584.00
393	Биет бус хөрөнгө	119,011,239.00	118,726,591.20
39301	Програм хангамж	1,423,239.00	1,423,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-284,647.80
39303	Бусад биет бус хөрөнгө	118,138,000.00	118,138,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,060,052,464.82	5,363,554,363.54
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	14,250,700.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	14,250,700.00
413	Өглөг	00.00	14,250,700.00
4136	Бусад өглөг	00.00	14,250,700.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	14,250,700.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,060,052,464.82	5,349,303,663.54
51	Засгийн газрын хувь оролцоо	5,060,052,464.82	5,349,303,663.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	842,334,698.00	842,334,698.00

51101	Өмч: - төрийн	842,334,698.00	842,334,698.00
512	Хуримтлагдсан үр дүн	692,853,209.93	982,104,408.65
51210	Өмнөх үеийн үр дүн	692,853,209.93	692,853,209.93
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	289,251,198.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,524,864,556.89	3,524,864,556.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,060,052,464.82	5,363,554,363.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,528,180,763.20	5,712,444,945.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	49,902,465.20	419,161,845.12
120	Нийтлэг татварын бус орлого	49,902,465.20	419,161,845.12
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,868,958.60	00.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,888,060.00	00.00
120018	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	10,388,428.00	36,453,400.00
120017	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/	10,388,428.00	36,453,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,478,278,298.00	5,293,283,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,401,569,698.00	5,207,730,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,212,229,700.00	5,207,730,100.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	189,339,998.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	76,708,600.00	85,553,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	76,708,600.00	85,553,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,048,829,535.06	5,423,193,746.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,048,829,535.06	5,423,193,746.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,807,444,735.06	5,156,302,146.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,061,810,060.27	4,092,812,056.00
210101	Үндсэн цалин	2,203,112,693.40	2,824,755,182.00
210102	Нэмэгдэл	730,274,521.80	1,040,782,791.00
210104	Урамшуулал	128,422,845.07	227,274,083.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	398,860,260.73	512,483,573.68
210201	Тэтгэврийн даатгал	272,047,378.00	351,132,163.00
210202	Тэтгэмжийн даатгал	31,703,220.00	40,747,857.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	25,362,577.00	20,544,629.68
210204	Ажилгүйдлийн даатгал	6,340,643.73	19,441,496.00
210205	Эрүүл мэндийн даатгал	63,406,442.00	80,617,428.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,768,850.00	83,849,750.00
210301	Гэрэл, цахилгаан	9,088,600.00	22,036,000.00
210302	Түлш, халаалт	68,180,250.00	61,313,750.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	749,500.00	00.00
210604	Урсгал засвар	749,500.00	00.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,954,267.00	91,837,552.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,864,400.00	35,453,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,089,867.00	56,384,152.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	241,301,797.06	375,319,214.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,509,899.00	76,248,270.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	38,385,200.00	103,581,746.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	162,406,698.06	195,489,198.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	241,384,800.00	266,891,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	241,384,800.00	266,891,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	241,384,800.00	266,891,600.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	479,351,228.14	289,251,198.72
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	23,812,857.39	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	23,812,857.39	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-23,812,857.39	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	455,538,370.75	289,251,198.72

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,090,041,328.00	5,315,485,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,334,028.00	22,202,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,334,028.00	22,202,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,334,028.00	22,202,700.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,334,028.00	22,202,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,084,707,300.00	5,293,283,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,027,562,500.00	5,207,730,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,027,562,500.00	5,207,730,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	57,144,800.00	85,553,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,144,800.00	85,553,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,028,151,648.71	5,212,579,492.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,028,151,648.71	5,212,579,492.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,902,509,948.71	4,945,687,892.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,604,801,608.71	4,143,861,000.00
210101	Үндсэн цалин	1,212,887,866.71	2,833,226,400.00
210102	Нэмэгдэл	351,083,782.00	1,144,820,100.00
210104	Урамшуулал	40,829,960.00	165,814,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	205,058,600.00	517,982,700.00
210201	Тэтгэврийн даатгал	3,280,600.00	352,228,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	16,404,600.00	41,438,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,124,000.00	20,719,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,280,700.00	20,719,300.00

210205	Эрүүл мэндийн даатгал	32,809,300.00	82,877,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,345,000.00	83,053,000.00
210301	Гэрэл, цахилгаан	3,619,800.00	17,033,000.00
210302	Түлш, халаалт	52,475,000.00	65,520,000.00
210303	Цэвэр, бохир ус	250,200.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	00.00	2,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,540,000.00	77,566,852.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	21,202,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,540,000.00	56,364,152.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,764,740.00	120,724,340.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,021,040.00	73,870,240.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,743,700.00	46,854,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	125,641,700.00	266,891,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	125,641,700.00	266,891,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	125,641,700.00	266,891,600.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	61,889,679.29	102,906,308.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	119,853,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	119,853,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	119,853,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	119,853,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-119,853,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	61,889,679.29	-16,946,692.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	49,876,188.00	350,665,873.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	111,765,867.29	333,719,181.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	842,334,698.00	3,524,864,556.89	-79,252,912.55	4,287,946,342.34
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	842,334,698.00	3,524,864,556.89	-79,252,912.55	4,287,946,342.34
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	336,324,770.33	336,324,770.33

C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	842,334,698.00	3,524,864,556.89	692,853,209.93	5,060,052,464.82
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	842,334,698.00	3,524,864,556.89	692,853,209.93	5,060,052,464.82
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	842,334,698.00	3,524,864,556.89	692,853,209.93	5,060,052,464.82
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	289,251,198.72	289,251,198.72
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	842,334,698.00	3,524,864,556.89	982,104,408.65	5,349,303,663.54

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		49,876,188.00		350,665,873.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,349,202,500.00	3,994,482,643.00	5,648,105,700.00	5,332,432,492.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,349,202,500.00	3,994,482,643.00	5,648,105,700.00	5,332,432,492.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,059,960,500.00	3,753,097,843.00	5,363,405,200.00	5,065,540,892.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,298,288,700.00	3,073,513,796.00	4,276,414,900.00	4,143,861,000.00
210101	Үндсэн цалин	2,249,407,000.00	2,073,497,817.00	2,965,780,300.00	2,833,226,400.00
210102	Нэмэгдэл	9,096,619,500.00	883,130,840.00	1,144,820,100.00	1,144,820,100.00
210104	Урамшуулал	142,262,200.00	116,885,139.00	165,814,500.00	165,814,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	412,286,100.00	398,779,200.00	534,551,900.00	517,982,700.00
210201	Тэтгэврийн даатгал	280,354,500.00	271,170,100.00	363,495,300.00	352,228,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	32,982,900.00	31,902,100.00	42,764,100.00	41,438,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	26,386,300.00	25,522,200.00	21,382,100.00	20,719,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,596,600.00	6,380,200.00	21,382,100.00	20,719,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	65,965,800.00	63,804,600.00	85,528,300.00	82,877,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,108,600.00	75,108,600.00	83,053,000.00	83,053,000.00
210301	Гэрэл, цахилгаан	9,088,600.00	9,088,600.00	17,033,000.00	17,033,000.00
210302	Түлш, халаалт	65,520,000.00	65,520,000.00	65,520,000.00	65,520,000.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	500,000.00	500,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,600,000.00	1,600,000.00	2,500,000.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	1,600,000.00	1,600,000.00	2,500,000.00	2,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,454,200.00	22,899,867.00	123,024,800.00	77,566,852.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,864,000.00	2,810,000.00	8,137,900.00	21,202,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	25,590,200.00	20,089,867.00	114,886,900.00	56,364,152.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	240,222,900.00	181,196,380.00	343,860,600.00	240,577,340.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	201,837,700.00	142,811,180.00	296,764,500.00	193,723,240.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	38,385,200.00	38,385,200.00	47,096,100.00	46,854,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	289,242,000.00	241,384,800.00	284,700,500.00	266,891,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	289,242,000.00	241,384,800.00	284,700,500.00	266,891,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	289,242,000.00	241,384,800.00	284,700,500.00	266,891,600.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,299,326,400.00	4,295,272,328.00	5,648,105,700.00	5,315,485,800.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,212,229,700.00	4,212,229,700.00	5,207,730,100.00	5,207,730,100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,212,229,700.00	4,212,229,700.00	5,207,730,100.00	5,207,730,100.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	76,708,600.00	76,708,600.00		
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	85,553,000.00	85,553,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	00.00	85,553,000.00	85,553,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	00.00	354,822,600.00	22,202,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,388,100.00	6,334,028.00	7,138,000.00	22,202,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,864,000.00	3,809,928.00	2,524,100.00	00.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	3,524,100.00	2,524,100.00	345,160,500.00	00.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	49,876,188.00	00.00	350,665,873.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	350,665,873.00	00.00	333,719,181.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь ерөнхий боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага юм. Тус сургууль нь 2024 онд “Сургалтын таатай орчин бүрдүүлж, тэгш хүртээмжтэй боловсролын үйлчилгээ үзүүлэх.Хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх, тэдний сурч хөгжих, хамгаалуулах, оролцох эрхийг хангана” гэсэн зорилгын хүрээнд 4 зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь Боловсролын Ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн

тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг зарим хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлтүүд орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас санхүүгийн баримтын шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй боловч уг баримт бичгийг шинээр гарсан хууль эрхийн актуудтай нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 303.5 сая төгрөгөөр буюу 6.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	350,665.87	333,719.18	(16,946.69)
Авлага	11,622.68	82,421.45	70,798.77
Урьдчилгаа			
Бараа материал	117,019.11	64,055.42	(52,963.69)
Үндсэн хөрөнгө	4,580,744.81	4,883,358.32	302,613.51
Нийт хөрөнгө	5,060,052.46	5,363,554.36	303,501.90
Өр төлбөр	-	14,250.70	14,250.70
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,060,052.46	5,349,303.66	289,251.20

Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,060,052.46	5,363,554.36	303,501.90
--	--------------	--------------	------------

Дээрх хүснэгтээс харахад авлага, үндсэн хөрөнгө дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө оны эцэст 333.7 сая төгрөг үлдэгдэлтэй гарч, оны эхнээс 16.9 сая төгрөгөөр буурсан байна. Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, бараа, үйлчилгээний зардал 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр санхүүжилт хийгдсэнээс гүйлгээ хийгдээгүй байна.

Нийгмийн даатгалын шимтгэлд 68.2 сая төгрөг илүү шилжүүлсэн болон түрээсийн номны орлогыг аккруэл сууриар бүртгүүлсэн залруулгатай холбоотой 14.2 сая төгрөг, оны эцэст нийт 82.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарч, оны эхнээс 70.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. байна.

Бараа материал данс оны эцэст 64.0 сая төгрөг болж, оны эхнээс 52.9 сая төгрөгөөр буурсан байна. Бичиг хэргийн материал 4.0 сая төгрөг, аж ахуйн материал 3.0 сая төгрөг, бусад хангамжийн материал 57.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,883.3 сая төгрөг болж, 302.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 119.8 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, үнэ төлбөргүй хүлээн авсан 378.2 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгөд 195.5 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өр төлбөр данс оны эцэст 14.2 сая төгрөг болж, оны эхнээс 14.2 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь түрээсийн номны орлогыг аккруэл сууриар бүртгүүлсэн залруулгатай холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5,349.3 сая төгрөг болж, 289.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 289.2 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сургуулийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,850.5 сая төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 76.1 сая төгрөгөөр, нийт зарлагыг 4,926.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас сургуулийн 2024 оны хувьсах зардлын төсвийг 4,156.2 сая төгрөгөөр хянаж, баталсан ба төсвийн тодотголоор 1,406.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 5,562.5 сая төгрөг болгон тодотгон баталжээ.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 74.1 сая төгрөгөөр хянаж, 2.0 сая төгрөгөөр бууруулан баталсан ба төсвийн тодотголоор 11.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 85.5 сая төгрөг болгон тодотгон баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,562.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 85.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, нийтдээ 5,648.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,207.7 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 85.5 сая төгрөгийн, нийт 5,293.2 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоор 22.2 сая төгрөг оруулж, оны эхний үлдэгдлээс 345.2 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,332.4 сая төгрөг болж, 94.4 хувийн биелэлттэй, 333.7 сая төгрөгийн дансны үлдэгдэлтэй гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Тус сургууль нь орон нутгийн төсвөөс орж ирсэн халаалтын зардлыг ТММН ХХК-д бүрэн шилжүүлж, дамжуулах үүргийг гүйцэтгэхээс гадна цалингийн зардлаасаа 8 галчийн цалин /үндсэн цалин, төрийн алба хаасан хугацааны, орон нутгийн болон бусад нэмэгдлүүд, ээлжийн амралтын олговор үүнд багтсан/, нийгмийн даатгалын шимтгэл, 7,8 дугаар сард цалингүй байх үеийн нийгмийн даатгалын шимтгэлд 91.5 сая төгрөг зарцуулсан байгаа нь хувийн компанийн зардлыг төр хариуцаж буй зохисгүй үйлдэл болж байна. Уурын зуухыг анх түрээсийн гэрээгээр ажиллуулж, сургуулийн балансад байсан боловч аймгийн удирдлагууд ТММН ХХК-д шилжүүлсэн байна. Харин газар нь сургуулийн балансад хэвээр байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/төгрөгөөр/

Д/Д	Арга хэмжээ	Код	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Байр ашиглалтын үйлчилгээ	80226	14,490,100.00	13,940,050.00	(550,050.00)	96.2
2	Сургалт семинар	80312	15,924,200.00	3,432,000.00	(12,492,200.00)	21.6
3	Эрүүл мэндийг дэмжих	81605	15,320,300.00	8,360,000.00	(6,960,300.00)	54.6
4	Үдийн цай хөтөлбөр	81801	284,700,500.00	266,891,600.00	(17,808,900.00)	93.7
5	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	81816	120,036,300.00	119,853,000.00	(183,300.00)	99.8
6	Боловсролын байгууллагын багш ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	81823	51,763,700.00	886,970.00	(50,876,730.00)	1.
7	Боловсролын стандарт сургалтын үйл ажиллагаа	81834	4,829,532,000.00	4,616,499,672.00	(213,032,328.00)	95.6
8	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	81835	181,668,500.00	181,668,500.00	-	100.0
9	Хүүхэд хамгаалалын зардал	80233	11,683,400.00	5,907,000.00	(5,776,400.00)	50.6
10	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	81844	5,048,200.00		(5,048,200.00)	
11	Сурах бичгийн түрээс	81848	8,137,900.00	22,202,699.00	14,064,799.00	100.0
12	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	81875	24,247,600.00	7,238,000.00	(17,009,600.00)	29.9
	Улсын төсвийн санхүүжилтийн дүн		5,562,552,700.00	5,246,879,491.00	(315,673,209.00)	94.0
	Нийтлэг үйлчилгээ ОН		85,553,000.00	85,553,000.00	-	100.0
	Орон нутгийн төсвийн санхүүжилтийн дүн		85,553,000.00	85,553,001.00	1.00	100.0
	Нийт дүн		5,648,105,700.00	5,332,432,492.00	(315,673,208.00)	94.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүү-нийцлийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд

Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь Ахмадын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан ажиллуулах журам”-ыг хэрэгжүүлээгүй буюу ахмадын сан байгуулж ажиллаагүй байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж ажиллаагүй байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 77.6 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлын дансаар 120.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулан авч хянаж үзэхэд Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дүгээр хамтарсан тушаалаар баталсан төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны жишиг нормативыг мөрдөн ажилласан байна.

Тус сургуулийн 1-12 дугаар сарын цалин олгох хүснэгтээр 163 хүнд цалин хөлс олгосон байна. Аймгийн Засаг даргын захирамжаар 163 орон тоо батлагдсанаас 163 хүн ажиллаж, байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Сургууль нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуульд Pearson /англи хэл/, Eduten /математик/ хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Бага ангийн сурагчдыг бүрэн хамруулсан байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь 2024 онд 101.7 сая төгрөгийн бараа материал, 119.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Анализ старт аудит” ХХК-ийн аудитор Ц.Саранцэцэг, шинжээч Д.Энхцаг нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг компанийн захирал Н.Энхтуяа, дараагийн шатны хяналтыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Анализ старт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 34 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,048.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 60.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай */өмнөх оноос улсын төсвийн санхүүжилт ихээхэн өссөн/* гэж үзсэн учир 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,423.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 81.3 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн мэдээлсэн байна. 1 мэдээллийг */Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан/* хугацаа хоцроож мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийхэд, дансны код сонголт, бичилт, ангилалтай холбоотой 4,124.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд зөвлөмж өгч, үйлчлүүлэгч байгууллагад Асуудлын бүртгэлээр хүргүүлсэн. 4,124.1 сая төгрөгийн алдааг залруулсан байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах зөвлөмж хэрэгжээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 48.3 сая төгрөгийн 1 зөвлөмж өгөгдсөнийг давтан шалгаж үзэхэд хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	48,300.0	1	48,300.0	100.0
Нийт дүн	1	48,300.0	1	48,300.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус сургуулийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байгаа халаалтын зардлыг “ТММН” ХХК-д бүрэн шилжүүлж, галч нарын цалин, нийгмийн даатгадын шимтгэлийг сургуулийн төсвөөс төлж байгаа асуудал болон худалдан авалт, цалингийн нэмэгдлүүдийн асуудлыг дараагийн аудитаар анхаарах шаардлагатай гэж үзэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 14.4 сая төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд 14.4 сая төгрөгийн залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд: Залруулсан алдаа:

- Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 14.2 сая төгрөгөөр дутуу,
- Бараа материалыг зарлагыг 0.2 сая төгрөгөөр илүү,
- Элэгдлийн зардлыг 0.09 сая төгрөгөөр дутуу илэрхийлснийг Санхүүгийн үр дүнгийн тайлан, Санхүүгийн байдлын тайлан, Бараа материалын тодруулгад тус тус залруулав.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 2.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 2.5 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Бичигдээгүй.

5.2 Албан шаардлага

1.Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 2/2772 дугаартай “Төсвийн шууд захирагч нарт” албан бичгээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар “Өөрчлөлтгүй дүгнэлт” авсан төсөв, санхүүгийн ажилтан нарт балансын урамшууллыг олгож болно гэснийг үндэслэн, сургуулийн захирлын 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн Б/46 дугаар тушаалаар нягтлан бодогч, нярав нарт 2.5 сая төгрөгийн урамшуулал олгож, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна.

2.Ажилтнуудад ур чадварын нэмэгдэл олгохдоо шалгуур үзүүлэлтээр дүгнэж олгосон боловч уг үзүүлэлт нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны А/35, А/10, 9, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 тушаалаар батласан шалгуур үзүүлэлттэй нийцэхгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" заалт, ажилтнуудад ур чадварын нэмэгдэл олгохдоо шалгуур үзүүлэлтээр дүгнэж олгосон боловч уг үзүүлэлт нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны А/35, А/10, 9, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 тушаалаар батласан шалгуур үзүүлэлттэй нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшуулал, холбогдох хууль, журам зөрчиж тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн олгохгүй байх, ур чадварын нэмэгдлийг холбогдох шалгуур үзүүлэлтээр дүгнэж олгож байх талаар албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Сургууль нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй /үдийн хоол 266.9 сая төгрөг, худалдан авсан үндсэн хөрөнгө 119.8 сая төгрөг г.м/ байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.1-т Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.”, 46.1-т “Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана.” гэсэн заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах;

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсөвт байгууллагын өөрийн орлогыг дутуу илэрхийлсэн.	1	14,250.7	1	14,250.7			1	14,250.7				
Элэгдлийн зардлыг дутуу илэрхийлсэн.	1	97.3			1	97.3	1	97.3				
Бараа материалыг үлдэгдлийг дутуу илэрхийлсэн.	1	0.2			1	0.2	1	0.2				
Дүн	3	14,348.2	1	14,250.7	2	97.5	3	14,348.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, тайлагнаагүй.	1	0					1	0				
Урамшуулал, ур чадварын нэмэгдэлтэй холбоотой	1	2,513.0			1	2,513.0						
Дүн	2	2,513.0			1	2,513.0	1	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нийт дүн	1	0					1	0